



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Мандалговь хот 2022 он	Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn Ахлах аудитор: Т.Батсайхан Утас: 70593113 Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn Аудитор: Д.Должинсүрэн Утас: 70593113 Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	11
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт.....	12
4.2 Албан шаардлага	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
НДСОТТТ	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.03.23 № 29

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012020886

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА



Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөг/			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,970,865.4	6,096,134.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	4,090,796.5	3,648,507.0
33	АВЛАГА	1,865,097.6	2,432,073.4
35	БАРАА МАТЕРИАЛ	14,971.3	15,554.5
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	472,437.2	447,865.2
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	472,437.2	447,865.2
39200	Биет хөрөнгө	454,521.2	426,598.6
39300	Биет бус хөрөнгө	17,916.0	21,266.6
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,443,302.6	6,544,000.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	137,065.0	29,434.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	137,065.0	29,434.3
41300	Өглөг	114,888.4	553.2
41400	Урьдчилж орсон орлого	22,176.6	28,881.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,306,237.6	6,514,565.8
51	Засгийн газрын хувь оролцоо	6,306,237.6	6,514,565.8
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	412,290.8	412,290.8
51200	Хуримтлагдсан үр дүн	5,754,513.9	5,962,842.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	139,432.9	139,432.9
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	6,443,302.6	6,544,000.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	45,551,155.6	44,785,415.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	17,900,174.5	18,750,353.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	17,900,174.5	18,750,353.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	56,551.0	64,999.3
120	Нийтлэг татварын бус орлого	56,551.0	64,999.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,594,430.1	25,970,063.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	41,248,125.7	44,640,441.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,248,125.7	44,640,441.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	605,644.3	586,103.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,786.8	413,419.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,213.0	53,918.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,582.9	32,494.8
2104	Хангамж, бараа материалын зардал	20,886.9	15,048.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	942.8	-
2107	Томилолт, зочны зардал	2,317.5	817.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,650.6	21,532.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	51,263.8	48,873.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,642,481.4	44,054,337.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	4,303,029.9	144,974.5
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,303,029.9	144,974.5

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,997,087.5	1,997,087.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	6,120.2	6,120.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,003,207.7	2,003,207.7
9	Тайлант үеийн үр дүн	4,303,029.9	4,303,029.9
10	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,306,237.6	6,306,237.6
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	63,353.8	63,353.78
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,369,591.3	6,369,591.34
19	Тайлант үеийн үр дүн	144,974.5	144,974.47
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	6,514,565.8	6,514,565.81

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	43,795,778.4	44,287,027.0
11	ТАТВАРЫН ОРЛОГО	16,228,865.1	18,200,965.3
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	16,228,865.1	18,200,965.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	71,627.8	103,476.1
120	Нийтлэг татварын бус орлого	71,627.8	103,476.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	27,495,285.5	25,982,585.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	41,140,064.3	44,729,316.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	41,140,064.3	44,729,316.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	549,158.0	538,253.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	418,786.8	413,419.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,213.0	53,918.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,582.9	32,494.8
2104	Хангамж, бараа материалын зардал	19,476.8	16,521.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,007.8	994.8
2107	Томилолт, зочны зардал	2,317.5	817.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,971.0	18,107.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	802.1	1,979.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,590,906.3	44,191,063.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,655,714.0	(442,289.5)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,655,714.0	(442,289.5)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,435,082.5	4,090,796.5
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,090,796.5	3,648,507.0

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	40,540,517.9	40,433,037.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	40,540,517.9	40,433,037.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	560,071.7	538,076.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	420,709.7	413,419.3

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,553.2	53,918.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	32,631.5	32,494.8
2104	Хангамж, бараа материалын зардал	20,252.5	16,521.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,500.0	994.8
2107	Томилолт, зочны зардал	2,207.8	817.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,217.0	17,930.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000.0	1,979.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,980,446.2	39,894,961.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	39,980,446.2	39,894,961.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	40,540,517.9	15,673,293.9
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,022,564.6	21,512.6
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,517,953.3	15,610,949.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	40,832.2
4	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	4,090,796.5
5	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	3,648,507.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1	1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	38	38

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	285.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	285.0
213	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	285.0
2133	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	285.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	285.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	285.0

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2/05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд НДЕГ-аас хяналт шалгалт хийгдээгүй. Харин Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь НДЕГ-ийн даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 6 арга хэмжээ, Дундговь аймгийн Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2 арга хэмжээг хэрэгжүүлэн, тэтгэвэр, тэтгэмж тогтоолт, олголтод хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 44,640,441.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 446,404.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 312,483.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 100,697.5 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага болон мөнгөн хөрөнгийн данс байна.

Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Хүснэгт 1

/мянган төгрөг/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн	5,970,865.4	6,096,134.9	125,269.5
Мөнгөн хөрөнгө	4,090,796.5	3,648,507.0	(442,289.5)
Авлага	1,865,097.6	2,432,073.4	566,975.8
Бараа материал	14,971.3	15,554.5	583.2
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	472,437.2	447,865.2	(24,572.0)
Үндсэн хөрөнгө	472,437.2	447,865.2	(24,572.0)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	6,443,302.6	6,544,000.1	100,697.5
Нийт өр төлбөр	137,065.0	29,434.3	(107,630.8)
Богино хугацаат өр төлбөр	137,065.0	29,434.3	(107,630.8)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,306,237.6	6,514,565.8	208,328.3
Засгийн газрын хувь оролцоо	6,306,237.6	6,514,565.8	208,328.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,443,302.6	6,544,000.1	100,697.5

Тайлант онд мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,648,507.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 442,289.5 мянган төгрөгөөр буурсан нь Нийгмийн даатгалын сангаас ковидын нөхцөл байдлаас шалтгаалан тэтгэмжийн болон ажилгүйдлийн сангийн зардал өндөр гарсантай холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 2,432,073.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 566,975.8 мянган төгрөгөөр өссөн нь төлбөртэй үйлчилгээний авлага буюу аж ахуйн нэгж байгууллагаас авах авлага нэг дахин өссөн, татаас санхүүжилтийн авлага буюу дээд шатны байгууллагаас нөхөн олгох төлбөрийн санхүүжилтийн авлага өссөн байна. Энэ нь ковидын нөхцөл байдалтай холбоотой даатгалын сангийн хууль, журмын хэрэгжилтэд өөрчлөлт орж, төрөөс олгох тэтгэмж өссөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 447,865.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 24,572.0 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлээ бүрэн нөхсөн 119,520.2 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийг данснаас хасаж 15,501.5 сая төгрөгөөр дахин үнэлж, орлого авсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансанд НДЕГ-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 6,820.2 мянган төгрөг, элэгдлээ бүрэн нөхсөн хөрөнгийг дахин үнэлж орлого авсан 15,501.5 мянган төгрөг, нийт 22,321.7 мянган төгрөгийн хөрөнгийг орлого авч, 48,141.4 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,514,565.8 мянган төгрөг болж 208,328.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн орлого бүрдүүлэлт

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 18,750,353.2 мянган төгрөг, татварын бус орлого 64,999.3 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 25,970,063.4 мянган төгрөгөөр тайлагнажээ. Үүнээс арилжааны банкны хүүгийн орлого 8,375.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 6 дахин буурсан, үндсэн үйл ажиллагааны орлого 36,010.4 мянган төгрөг болж 11 дахин өссөн байна. Энэ нь ковидын нөхцөл байдлаас шалтгаалан 2021 онд арилжааны банкны хүүг зогсоосон мөн 2020 онд ковидын нөхцөл байдлаас шалтгаалан нийгмийн даатгалын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй, алданги, торгуулийг зогсоосон зэргээс шалтгаалсан байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн нийгмийн даатгалын санд 13,928,376.1 мянган төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 15,673,293.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 112.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого /мянган төгрөг/

Сангийн орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Тэтгэвэр	12,195,959.6	13,601,167.3	1,405,207.70	111.5
Тэтгэмж	970,287.0	1,134,602.7	164,315.70	116.9
ҮОМШӨ	577,772.8	718,691.9	140,919.10	124.4
Ажилгүйдэл	184,356.7	218,832.0	34,475.30	118.7
Дүн	13,928,376.1	15,673,293.9	1,744,917.80	112.5

Эх сурвалж: Нийгмийн даатгалын санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд Нийгмийн даатгалын санд оруулах орлогыг 15,448,000.0 мянган төгрөг, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 40,976,100.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 40,976,100.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сангийн орлогыг 1,519,623.9 мянган төгрөгөөр бууруулж, 13,928,376.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 17 хувь буюу 2 хувиар буурсантай холбоотой байна. Зарлагыг 435,582.1 мянган төгрөгөөр бууруулан 40,540,517.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 15 арга хэмжээг санхүүжүүлэхээр Нийгмийн даатгалын сангийн төсвөөс 40,540,517.9 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр дээд шатны төсөв захирагчаас 25,960,788.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийгмийн даатгалын сангийн орлогоос 18,761,949.0 мянган төгрөгийг санхүүжүүлж, нийт гүйцэтгэлээр 40,433,037.4 мянган төгрөгийг зарцуулж, 4,289,699.6 мянган төгрөгийг дээд шатны байгууллагад төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 40,433,037.4 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

Энэ нь тэтгэвэр, ҮОМШӨ сангийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна. Тэтгэмжийн даатгалын даатгалын сангийн төсөв 1 хувиар хэтэрсэн нь аймгийн хэмжээнд төрөлт ихсэж жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосонтой холбоотой. НДСОТТТ хуульд тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгохоор заасны дагуу хугацаанд нь олгож даатгуулагчийн эрх ашгийг хамгаалж ажилласан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 285.0 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр сургалт сурталчилгаанд олгосныг зарцуулалгүй буцааж шилжүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд дараах онцлох асуудлууд байна. Үүнд:

1. НДЕГ-аас 6,820.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэн авсан;
2. Нийгмийн даатгалын сангийн тэтгэмжийн зарцуулалт батлагдсан төсвөөс 1 хувиар хэтэрсэн боловч нийт сангийн батлагдсан төсвөөс хэтрээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2021 оны Нийгмийн даатгалын сангийн цахим хуудсыг шалгахад нийт 39,977,679.9 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн, байршуулахаас 39,977,679.9 мянган төгрөгийн 165 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Харин Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийг шалгахад нийт 619,978.4 мянган төгрөгийн 3 мэдээллийг хугацаа хоцроож, 619,978.4 мянган төгрөгийн 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

1. Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны цахим хуудсанд илэрсэн зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан байна. 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлээгүй тул завсрын аудитаар нийгмийн даатгалын сангийн зарцуулалтад горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар шидэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

4.2 Албан шаардлага

Аудитаар илэрсэн дараах зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант хугацаанд Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроож, 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/ д	Алдаа, зөрчлийн утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
	Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагааны шилэн дансны 3 мэдээллийг хугацаа хоцроож, 16 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.	1						1			
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1											
	Нийт зөрчлийн дүн	1				-	-	1			